

**“БИЗНЕСИЙН ОРЧНЫ ШИНЭТГЭЛИЙН ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД  
МХЕГ-ААС ХИЙЖ БАЙГАА АЖЛЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

2010.11.16

“Бизнесийн орчны шинэтгэлийн жил” 2010 онд МХЕГ-аас “Хяналт шалгалтын үйл ажиллагааны шинэчлэлийг гүнзгийрүүлж, бизнесийн үйл ажиллагааг хөнгөвчлөх” зорилт дэвшүүлэн бизнест учирч буй хяналт шалгалтын дарамт, чирэгдлийг багасгах, хяналт шалгалт түүний шийдвэр гаргалтын ил тод байдлыг хангах, бизнес эрхлэгчдийн эрхийг хамгаалах чиглэлээр эрх зүйн болон үйл ажиллагааны шинэчлэлийн багагүй ажлыг хийж гүйцэтгэлээ.

Олон Улсын Санхүүгийн Корпорацитай хамтран хэрэгжүүлж байгаа “Бизнесийн хяналтын шинэчлэл” төслийн хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, энэ оны 6 дугаар сарын 10-ны өдөр УИХ-аар батлагдсанаар Мэргэжлийн хяналтын салбарт томоохон өөрчлөлт шинэчлэлийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдлээ.

Хуулинд шинээр 6 зүйлийн 37 заалт шинээр нэмж, 47 заалтыг өөрчлөн найруулах буюу шинэчлэн, нийт 84 заалт тусгасны 50-иас илүү хувь нь хяналт шалгалтыг эрсдлийн үнэлгээнд тулгуурлан хэрэгжүүлэх, шалгалтын ил тод, байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Хяналтын хуудас”-ыг нэвтрүүлэх, хяналт шалгалтын байгууллагын хараат бусаар ажиллах нөхцлийг бүрдүүлэх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор авч байгаа лабораторийн дээжийн үнийг төр хариуцах, хяналтын зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх зэрэг бизнэс эрхлэгчдийн эрхийг хамгаалах, хяналтын байгууллагын үйл ажиллагаа, хяналт шалгалтын ил тод байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулсан заалтууд байна.

Өөрөөр хэлбэл, бизнес эрхлэх таатай орчныг дэмжих, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг олон улсын жишиг, шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд хийсэн томоохон ажил боллоо.

Хууль хэрэгжиж эхэлсэнээс хойших хугацаанд эрсдлийн үнэлгээ хийх аргачлал болон “хяналтын хуудас” боловсруулах, туршин хэрэгжүүлэх, мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх сургагч багшийг улсын байцаагчдаас бэлтгэх ажлыг дэс дараатай эхлүүлж, 40 сургагч багшийг 3 үе шаттай бэлтгэхэд Олон улсын санхүүгийн корпорацийн гадаад зөвлөхүүдийг урьж хамтран ажиллав. Хүнсний аюулгүй байдал болон байгаль орчны хяналтын чиглэлээр объектыг эрсдэлийн их, дунд, бага ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг боловсруулж, улсын байцаагчид, МХЕГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүд болон аж ахуйн нэгжийн 40 гаруй төлөөллийг оролцуулан 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулав. Эдгээр ажлын үр дүнд 2011 онд хүнсний аюулгүй байдал болон байгаль орчны хяналтын чиглэлээр эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бэлтгэл хангагдаж байна.

Хяналт шалгалтыг шалгуулагчид ойлгомжтой, ил тод, хараат бусаар хэрэгжүүлэх, шалгагч шалгуулагчийн хооронд “улаан шугам” татах зорилгоор өндөр хөгжилтэй орнууд болон хяналт шалгалтын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж байгаа зүүн Европын зарим улсуудын хяналтын байгууллагуудад хэрэглэгдэж буй “хяналтын хуудас”-уудыг орчуулан судалж, хяналт шалгалтад хэрэглэгдэх “хяналтын хуудас”-ны ерөнхий загварыг боловсруулан, улсын байцаагчид, Олон нийтийн зөвлөлийн гишүүд болон бизнес эрхлэгчдийн төлөөлөлийг оролцуулан хэлэлцүүлж, тэдний санал зөвлөмжийг тусган эцэслээд байна. Одоогоор хүнсний аюулгүй байдал, байгаль орчны чиглэлээр боловсруулаад байгаа 8 хяналтын хуудсуудыг хяналт

шалгалтад нэвтрүүлснээр хяналт шалгалтын ил тод байдал хангагдах, хяналтын бусад чиглэлээр хяналтын хуудас боловсруулахад үлгэрчилсэн загвар болох боломж бүрдээд байна.

Дээрх ажлуудаас гадна МХЕГ-аас бизнес эрхлэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар, шуурхай байдлыг дээшлүүлэх, гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр авч хэрэгжүүлсэн дараах арга хэмжээг онцолж байна. Тухайлбал,

1. Мэргэжлийн хяналтын байгууллагаас олгож байгаа гэрчилгээ, мэдэгдэл, дүгнэлт зэрэг зөвшөөрлийн шинжтэй баримт бичгийг цөөрүүлэх үүднээс тус газраас олгож ирсэн зөвшөөрөл, дүгнэлтэд ажлын зураг авалт хийж, шат дамжлага, зарцуулагдаж буй хугацаа, бүрдүүлэх материал зэргийг судлан тогтоож, зөвшөөрөл хэлбэрээр ойлгогддог дүгнэлтүүдийн эрх зүйн үндэслэлд судалгаа хийсний үндсэн дээр тус байгууллагаас олгож байгаа зөвшөөрлийн шинжтэй 55 баримт бичгийн 13-ыг холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар зохих байгууллагуудад шилжүүлэх, 9-ийг нь Засгийн газрын тогтоол, сайдын тушаалаар батлагдсан журамд өөрчлөлт оруулах замаар хүчингүй болгох саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2. Бизнес эрхлэгчдэд хүндрэл чирэгдэл учруулж, нийгмийн зүгээс ихээхэн шүүмжлэл хүлээж, хяналт шалгалтын давхардал гарах нөхцөлийг бүрдүүлж байсан "Ажлын байрны дүгнэлт"-ийг хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтаас бусад хяналтын чиглэлээр гаргахгүй байхаар шийдвэрлэсний үр дүнд хяналт шалгалтын тоо тодорхой хувиар багасах боломж бүрдэж байна.

3. Шаардлагатай бичиг баримтаа бүрдүүлсэн импортлогч иргэн, аж ахуй нэгж, байгууллагад импортын мэдэгдлийг хуульд заасан 14 хоногийн хугацаанаас цөөн буюу ажлын 1-3 хоногт багтаан олгож байна.

4. Улсын хилээр нэвтрүүлэх бараа, бүтээгдэхүүний дээжийг стандартын дагуу 3 сар тутамд лабораторийн шинжилгээнд хамруулж байсныг чанар, аюулгүй байдлын шардлага хангасан байдал, зөрчлийн түүх зэрэг шалгуурыг харгалзан 6 сар болгож хугацааг сунгалаа.

5. Улаанбаатар хотын гүний терминалаар нэвтрүүлж буй ургамлын гаралтай бүтээгдэхүүнд олгох импортын мэдэгдэлийг МХЕГ-аас НМХГ-т шилжүүлж, шат дамжлагыг багасгалаа.

6. Барилга угсралтын ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоход 8 хяналтын чиглэлээр улсын байцаагч гарын үсэг зурж байсныг 4 болгож, Засгийн газрын 2009 оны 72 дугаар тогтоолоор баталсан дүрмийн дагуу барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд хяналтын 12 чиглэлээр улсын байцаагч гарын үсэг зурдаг байсныг 8 болгож тус тус цөөрүүллээ.

7. Мөн улсын чанартай объектоос бусад бүх барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комисс ажиллуулах чиг үүргийг аймгуудын МХГ-т шилжүүллээ.

8. Бизнесийн таатай орчин бүрдүүлэх зорилгоор гадны дэвшилтэд стандарт нэвтрүүлэх, стандартуудыг шинэчлэх, шинээр боловсруулах ажлын хүрээнд хүнсний болон байгаль орчны чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартуудыг судлан дүн шинжилгээ хийж, цаашид хэвээр мөрдөх болон шинээр мөрдүүлэх шаардлагатай стандартуудын жагсаалтыг салбар тус бүрээр гаргаж, олон улсын чанарын удирдлагын болон Европын холбооны стандартын шаардлагад нийцсэн хүнсний үйлдвэрлэлийн чиглэлийн 3, байгаль орчны чиглэлийн 2 стандартыг орчуулан нэвтрүүлэх ажлыг "Судалгааны баг"-аар гүйцэтгүүлж байна.

Хяналт шалгалтын ажил, үйлчилгээг ёс зүйтэй хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоог хангах чиглэлээр дараах ахиц гаргалаа.

• Төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Олон нийтийн зөвлөлийг МХЕГ-ын дэргэд байгуулан ажиллуулж байна.

- Мэргэжлийн хяналтын байгууллагын одоогийн хэрэгжүүлж байгаа хяналтын чиг үүрэг, хамрах хүрээг эрх зүйн хүрээнд судалж, цаашид хэрэгжүүлэх хяналтын чиг үүрэг, хамрах хүрээг оновчтой тогтоох, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх боломжтой хяналтын чиг үүргийг тодорхойлох ажлыг "Хууль судлалын төв" төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна.
- БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдах МХЕГ-ын Нэгдсэн төв лабораторийн барилга угсралтын ажлыг энэ оны 4 дүгээр сард эхлүүлсэн бөгөөд ирэх онд ашиглалтад оруулснаар лабораторийн шинжилгээний хүчин чадал 2.5 дахин нэмэгдэж, хяналт шалгалтыг шуурхай явуулах боломж дээшилнэ.
- МХЕГ-т нэг цэгийн үйлчилгээний төв байгуулж, баримт бичгийг цахим хэлбэрээр шийдвэрлэх эхлэлийг тавилаа.
- Мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын түвшин тогтоох улсын үзлэгийг системийн хэмжээнд анх удаа зохион байгуулж, түүний үр дүнд тулгуурлан Мэргэжлийн хяналтын байгууллагын "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр", "Сургалтын хөтөлбөр", "Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг тус тус шинээр боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн ба боловсон хүчний сургалт, хөгжлийн асуудал хариуцсан нэгж бий болгож, 2-3 хоногийн сургалт семинарт хамруулах төдийгөөр хязгаарлагдаж ирсэн өмнөх арга хэлбэрийг өөрчилж, сургагч багш бэлтгэх, кредит цагийн сургалтыг нэвтрүүлэх зэрэг сургалтын дэвшилт арга туршлагыг хэрэглэж байна.
- Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг шинэчлэн баталж, МХЕГ-ын дэргэд Ёс зүйн хороог шинээр байгуулан, улсын байцаагчийн ёс зүйтэй холбоотой санал, шүүмжлэл, зүй бус үйлдлийг хянан шийдвэрлэх механизмыг бүрдүүлсэн ба 1286 нээлттэй утсыг ажиллуулж байна. Мөн Төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын бүх шатны удирдах ажилтнууд "Авлигаас ангид, ёс зүйтэй хяналтыг төлөвшүүлэх мэдэгдэл"-д гарын үсэг зурж, үүрэг хариуцлагаа дээшлүүлэх амлалт авлаа.

-----oOo-----